

## “ХҮНДЭТ ДОКТОР” ЦОЛ ӨРГӨМЖЛӨВ

Монгол Улсын гадаад бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх, ялангуяа хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын дипломат албыг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн ахмад дипломатч, Элчин сайд С.Дамбадаржаагийн 85 насны ойг тохиолдуулан Монгол Улсын ГХЯ, тус яамны дэргэдэх Ахмадын хорооноос эрдэм шинжилгээний бага хурлыг 2006 оны 6 дугаар сарын 14-нд ГХЯ-ны хурлын танхимд зохион байгуулав.

Эрдэм шинжилгээний бага хурлын үеэр элчин харилцаа, дипломат алба, олон улс судлалыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг нь үнэлэн ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн шийдвэрээр ахмад дипломатч, судлаач С.Дамбадаржаад “Хүндэт доктор”-ын цол өргөмжлөв. Ахмад дипломатч, Элчин сайд С.Дамбадаржаа нь 12 улсад эх орноо төлөөлөн элчин сайдаар ажиллаж, гадаад харилцааны салбарт 30 шахам жил ажиллажээ. Мөн тэрбээр гадаад харилцаа, Монгол-Японы харилцаагаар 2 ном бичиж хэвлүүлсэн бөгөөд 40 шахам судалгааны өгүүлэл, тэмдэглэл туурвижээ.

“Хүндэт доктор”-ын цол өргөмжлөх үеэр ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D), профессор Л.Хайсандай хэлсэн үгэндээ “С.Дамбадаржаа гуай бол өндөр мэдлэг боловсролтой, туршлагатай судлаач хүн. Олон улсын харилцаа, орон судлаач хүний хувьд Дамбадаржаа гуайн туурвисан судалгааны ажлууд нь утга агуулга сайтай, шинэ соргог санаа ихтэй, дүгнэлт гаргалгаа жинтэй байдаг. Тэгээд ч бид судалгааны ажилдаа тэр бүгдийг нь олзуурхан авч, ашиглах сонирхолтой байдаг.

С.Дамбадаржаа гуай дээрх өгүүлэл, тэмдэглэл бүртээ тодорхой асуудал дэвшүүлсэн байхаас гадна Ази, Европ, Арабын орнуудын соёл, ахуй амьдрал, зан заншил, боловсрол, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн талаар, тухайн орон болон Монгол Улсын харилцааны байдал, хэтийн төлвийн талаар олон шинэ санаа, шинэлэг үнэлэлт дүгнэлт тусгагдсан байдаг.

С.Дамбадаржаа гуай судалгааны ямар нэгэн өгүүлэл бичихдээ баримталдаг нэг онцлог зарчим байна. Тэр нь бодитой, тодорхой, оновчтой өгүүлэх арга барил юм. Жишээлбэл хоёр улсын харилцааны тухай бичихдээ заавал түүний ирээдүйн төлөв, Монгол Улсын хөгжилд хэр үр ашигтайг нарийн гаргаж тавьсан байдаг. Энэ бол судлаач хүнд байх ёстой шинж, шилдэг арга барил, шилдэг ёс суртахуун юм.

С.Дамбадаржаа гуай дэлхийн хэмжээнд нүд тайлж, дэлхийн хэмжээний хүмүүстэй учирч, дэлхийн хэмжээнд бодож сэтгэж, хийж бүтээж явсны гэрч баталгаа нь тэрээр бичиж нийтлүүлсэн дээрх

бүтээлүүд байна. Эдгээр бүтээлд дурсаж өгүүлсэн, бичиж хүүрнэсэн үйл явдал бүхэн нь, ургуулж бодсон уран санаа, ухаалаг хэрсүү үг өгүүлбэр бүр нь бид бүхэнд, манай залууст Монголын олон улс судлалын үйл хэрэгт ихээхэн ач тустай, үнэ цэнэтэй болохыг эцэст нь дүгнэж хэлье.

Энэхүү “Хүндэт доктор”-ын хэргэмийг урьд нь Америкийн нэртэй эрдэмтэн, профессор Роберт Скалапино, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан ноён Жеймс Бейкер, Японы элчин сайд, монголч эрдэмтэн Марохито Ханада, Оросын эрдэмтэн, академич Ростаслав Рыбаков, элчин сайд Олег Дерковский, Хятадын элчин сайд Хуан Жякуй, НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч, хатагтай Пратиба Мехта, Монголын эрдэмтэн, зохиолч Лодонгийн Түдэв, нэртэй дипломатч, элчин сайд Баярын Жаргалсайхан, элчин сайд, орчуулагч Цэрэнпилийн Гомбосүрэн, профессор Л.Моломжамц гуай нарт хүртээж байсан юм” хэмээн онцлон тэмдэглэв.